

2017-2019 онд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хийгдсэн эрдэм шинжилгээний ажлуудад хийсэн тойм судалгааны үр дүн

Төрийн өмчит орон нутгийн эрүүл мэндийн ажиллагсдын 2017-2019 онд хийсэн судалгааны талаарх мэдээллийг эрдэм шинжилгээний ажлын нэр, судлаач, судалгааны ажлын зөвлөх болон хамтрагч, судалгааны арга, аргачлал, олон улсын байгууллагатай хамтарсан эсэх, , шинжлэх ухааны сэтгүүлд хэвлэгдсэн байдал, санхүүжилттэй эсэх талаарх мэдээллийг ЭМХТ-ийн 2020 оны А/370 тоот албан бичгээр эрүүл мэндийн байгууллагуудаас цуглуулан ирүүлсэн мэдээлэлд тойм судалгаа хийв. Нийт 20 аймгийн эрүүл мэндийн байгууллага судалгааны мэдээллийг ирүүлсэн ба ихэнх орон нутгийн эрүүл мэндийн ажиллагсад эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа нь харагдлаа.

Хүснэгт 1. Төрийн өмчит орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад 2017-2019 онд хийгдсэн судалгааны тоо, аймгаар

№	Аймгийн нэр	Хийгдсэн судалгааны тоо
1	Архангай аймаг	5
2	Баян-Өлгий аймаг	31
3	Баянхонгор аймаг	40
4	Булган аймаг	70
5	Говь-Алтай аймаг	3
6	Говьсүмбэр аймаг	23
7	Дархан-Уул аймаг	38
8	Дорноговь аймаг	106
9	Дорнод аймаг	40
10	Дундговь аймаг	25
11	Завхан аймаг	8
12	Өвөрхангай аймаг	14
13	Өмнөговь аймаг	43
14	Сүхбаатар аймаг	36
15	Сэлэнгэ аймаг	8
16	Төв аймаг	4
17	Увс аймаг	41
18	Ховд аймаг	20
19	Хөвсгөл аймаг	5
20	Хэнтий аймаг	21
	Нийт	581

Төрийн өмчит орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад 2017-2019 онд нийт 581 эрдэм шинжилгээний ажил хийгдсэн байна. Орхон аймаг судалгааны мэдээлэл ирүүлээгүй ба Ховд, Сүхбаатар аймгуудын ирүүлсэн мэдээлэл хангалтгүй байлаа.

Тооны хувьд хамгийн олон судалгаа хийсэн аймгуудад 1-рт 106 судалгааны ажил хийсэн Дорноговь, 2-рт 70 эрдэм шинжлгээний ажил туурвисан Булган, 3-рт

43 судалгаа хийсэн Өмнөговь аймаг тус тус орж байна. Харин 3 жилийн хугацаанд Говь-Алтай аймаг 3, Төв аймаг 4, Архангай болон Хөвсгөл аймаг тус бүр 5, Завхан, Сэлэнгэ, аймгууд тус бүр 8 судалгааны ажил хийсэн нь дээрх аймгуудын эрүүл мэндийн ажилтнуудын эрдэм шинжилгээний ажлын идэвх сул байгааг харуулж байна.

Дорноговь аймаг жил бүр тогтвортой 30-аас 40 гаран, Булган аймаг жил бүр 20 гаран, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Увс аймгууд тус бүр 10 орчим бүтээлийг тус бүр хийсэн байлаа.



Судалгаанд хамрагдсан аймгуудын хувьд 2017 онд нийт 159, 2018 онд 196, 2019 онд 226 эрдэм шинжилгээний бүтээл туурвисан нь жил бүр хийгдэх судалгааны тоо дунджаар 27%-ийн өсөлттэй байгаа нь сайшаалтай байлаа.


Хүснэгт 2. Төрийн өмчит орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад 2017-2019 онд хийгдсэн судалгаа, аймгаар

	Аймгийн нэр	2017 он	2018 он	2019 он	Нийт
1	Архангай аймаг	1	2	2	5
2	Баян-Өлгий аймаг	10	11	10	31
3	Баянхонгор аймаг	7	11	22	40
4	Булган аймаг	25	22	23	70
5	Говь-Алтай аймаг		1	2	3
6	Говьсүмбэр аймаг	10	6	7	23
7	Дархан-Уул аймаг	15	11	12	38
8	Дорноговь аймаг	31	32	43	106
9	Дорнод аймаг	11	13	16	40
10	Дундговь аймаг	3	10	12	25
11	Завхан аймаг		0	8	8
12	Өвөрхангай аймаг	6	7	1	14
13	Өмнөговь аймаг	8	8	27	43
14	Сүхбаатар аймаг	9	14	13	36
15	Сэлэнгэ аймаг	3	2	3	8
16	Төв аймаг	2	1	1	4
17	Увс аймаг	12	18	11	41
18	Ховд аймаг	3	10	7	20
19	Хөвсгөл аймаг	1	4	0	5
20	Хэнтий аймаг	2	13	6	21
	Бүгд	159	196	226	581

Аймгуудаар нь авч үзвэл Баянхонгор аймагт 2017 онд 10 хүрэхгүй тооны судалгаа хийж байсан бол 2 жилийн дотор хийсэн эрдэм шинжилгээний тоо 3 дахин нэмэгдэж 2019 онд 21 судалгаа хийсэн огцом өсөлттэй байна. Харин Говьсүмбэр, Өвөрхангай аймгуудад жил ирэх тусам хийгдсэн судалгааны тоо бууралттай байна.



Орон нутагт хийгдсэн нийт судалгааны 30 хүрэхгүй хувь нь /28%/ зөвлөхтэй байсан ба 3 судалгаа тутмын 2 нь албан ёсны зөвлөгч буюу чиглүүлэгчгүй, судалгааны чанар болон үр дүнд тавих хяналтгүй, зөвлөн чиглүүлэх үйл ажиллагаа хэрэгжээгүй сул тал ажиглагдлаа.



2017-2019 онд орон нутагт хийгдсэн нийт судалгааны дийлэн буюу 68% хувийг эмч нар гардан гүйцэтгэсэн байна. Булган, Говь-Алтай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгийн сувилагч болон эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд эрдэм шинжилгээний судалгааны ажилд оролцоогүй ба Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Увс аймгийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд аймгийн эмч нараасаа илүүтэй судалгааны ажил туурвисан байна.



Нийт судалгааны 62% нь эмнэлзүйд түшиглэсэн, 38% нь бодлогын судалгааны чиглэлээр хийгдсэн байв. Судалгааны аргын хувьд эмч, сувилагч нар нь эрхлэж буй ажлын хүрээнд цуглуулсан мэдээлэлд эргэмж судалгаа хийх нь давамгайлсан ба хугацаа, цаг, хүч хөдөлмөр ихээр шаардсан кохорт судалгааг Сэлэнгэ, Булган аймгуудад хийсэн сайшаалтай тал судалгаанаас харагдлаа. Орон нутгийн судлаачид нь судалгааны арга болон судалгааны мэдээлэл цуглуулах аргуудаа хооронд нь ялгаж зааглаж чадаагүй байсан нь энэ талын мэдлэг хомс байгааг харуулж байна. Мөн нотолгооны түвшин өндөр болох мета анализ, систематик review ашигласан судалгаа хараахан хийгдээгүй байв.

Мөн нийт эрдэм шинжилгээний бүтээлийн ердөө 13% нь голчлон дотоодын анагаахын мэргэжлийн сэтгүүл, ном, эмхэтгэлд хэвлэгджээ. Харин Архангай аймгийн эрүүл мэндийн ажилтны 2018 онд хийгдсэн "С вирүст хепатиттай хүмүүсийн С вирүсийн эсрэг эмчилгээний үр дүн" судалгааны үр дүнг Номхон далайн баруун бүсийн анагаах ухааны сэтгүүл"-д хэвлүүлсэн нь сайшаалтай байна. Эрүүл мэндийн ажилтнууд дотоод нөөц бололцоог ашиглан судалгаа хийсэн ба олон улсын байгууллагатай хамтарсан, санхүүжилттэй, захиалгат судалгаа маш цөөн байгаа нь ажиглагдлаа.

Цаашид

- Аймгийн ЭМГ-ын зүгээс эрүүл мэндийн ажилтнуудын эрдэм шинжилгээний бүтээл туурвих идэвх санаачлагыг нэмэгдүүлэх, /ялангуяа Архангай, Говь-Алтай,Төв, Хөвсгөл аймгууд/,
- Судалгааны ажил эрхэлсэн ажилтнуудыг дэмжих, урамшуулах чиглэлээр анхаарч, арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Жил бүрийн төсөвт судалгааны ажилд зориулсан санхүүжилтыг төлөвлөх
- Эрүүл мэндийн ажилтнуудын эрдэм шинжилгээний арга зүйн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах
- Судлаачдын зүгээс судалгаа хийхдээ албан ёсны зөвлөхийг сонгох, заавар, зөвлөлгөө, чиглэл авах хэвшил бий болгоход анхаарах
- Судалгааны үр дүнг шийдвэр гаргагчдад хүргэх, нотолгоо болгон ашиглахад анхаарч ажиллах
- Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахад идэвх санаачлагатай ажиллах анхаарах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Олон улсын эрдэм шинжилгээний "Тархвар зүйн нээлттэй сэтгүүл"-д хэвлүүлсэн " Архангай аймгийн С вирүст хепатитын эрт илрүүлэг ба эрсдэлт хүчин зүйлийн судалгааны үр дүн"-г энд дарж харна уу.